

**Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан
зардлыг нөхөн төлөх тухай гэрээ**

2017 оны 08 дугаар
сарын 09-ны өдөр

дугаар ХАЗ-2017/.../...

Улаанбаатар
ХОТ

Ерөнхий зүйл

Нэг талаас Ашигт малтмал, Газрын тосны газар /цаашид Агентлаг гэх/, нөгөө талаас Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах Өмнөд MV-18914, Зөөвч-Овоо MV-018915, Дулаан-Уул MV-018916 дугаартай, нийт 53,292.43 га талбайтай цацраг идэвхит ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий ордуудыг 2016 оны 09 дугаар сарын 15-ны өдөр АМГТГ-тай байгуулсан Орд Ашиглах Гэрээний үндсэн дээр эзэмшигч 5502977 тоот регистрын дугаартай, 9011302095 тоот гэрчилгээ бүхий АРЕВА Майнс ХХК (цаашид “аж ахуйн нэгж”, хамтад нь “Талууд” гэнэ) нь Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Өмнөт, Зөөвч-Овоо, Дулаан-Уул орд дээр хийгдсэн эрэл, эрэл үнэлгээ, нарийвчилсан хайгуулын ажлын зардлуудыг улсын төсөвт эргүүлэн нөхөн төлөх нөхцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь 2016 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр талуудын хооронд байгуулагдсан Орд ашиглах тухай гэрээг үндэслэл болгон байгуулагдсан болно.

**Нэг. Ерөнхий эрэл, урьдчилсан хайгуул, нарийвчилсан хайгуул,
гидрогеологийн хайгуул, зураглалын ажлын зардлын нийт хэмжээ**

1.1 Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Өмнөт, Зөөвч Овоо, Дулаан Уул орд орших талбайд хийсэн эрэл, хайгуулын ажил хийгдсэн бөгөөд Ашигт малтмалын ашиглалтын MV-18914, Зөөвч Овоо MV-018915, Дулаан Уул MV-018916 дугаартай тусгай зөвшөөрлүүдийн талбайд ноогдох нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу тооцоход **1,492,178,770.34** төгрөг болж байгааг хоёр тал хүлээн зөвшөөрөв. Талууд тооцооллыг харилцан хүлээн зөвшөөрч буй талаар 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр бичигт тэмдэглэн гарын үсэг зурсан болно.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх хүлээх үүрэг, хариуцлага

2.1 Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан зардлыг 4 жилийн хугацаанд төлөх бөгөөд төлбөрийг төгрөгөөр төлнө.

2017 оны 4 дүгээр улиралд энэхүү гэрээний 1.1-д заасан үнийн дүнгийн 10 хувь буюу 149.217.877,5 (нэг зуун дөчин есөн сая хоёр зуун арван долоон мянга найман зуун далан долоон төгрөг таван мөнгө)

2018 оны 2 дугаар улиралд энэхүү гэрээний 1.1-д заасан үнийн дүнгийн 20 хувь буюу 298,435,754.07 (Хоёр зуун ерэн найман сая дөрвөн зуун гучин таван мянга долоон зуун тавин дөрвөн)

2019 оны 2 дугаар улиралд энэхүү гэрээний 1.1-д заасан үнийн дүнгийн 20 хувь буюу 298,435,754.07 төгрөг (Хоёр зуун ерэн найман сая дөрвөн зуун гучин таван мянга долоон зуун тавин дөрвөн төгрөг)

2020 оны 2 дугаар улиралд энэхүү гэрээний 1.1-д заасан үнийн дүнгийн 50 хувь буюу 746.089.385,17 (долоон зуун дөчин зургаан сая наян есөн мянга гурван зуун наян таван төгрөг арван долоон мөнгө)

2.2 Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2.1-т дурьдсан оны тухайн улиралд төлөхөөр хуваарилсан төлбөрийг тухайн онд хавсралт 1-д заасан хугацаанд Төрийн сан банкны төгрөгийн **100900000722** тоот Ашигт малтмал, газрын тосны газрын Нөхөн төлбөрийн дансанд төлнө. Төлбөрөө төлөхдөө гүйлгээний утга хэсэгт тусгай зөвшөөрлийн дугаар, Ашигт малтмалын тусгай зөвшөөлийн дугаарыг тодорхой бичнэ.

2.3 Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр төлсний дараа уг төлбөр Ашигт малтмал газрын тосны газрын Нөхөн төлбөрийн дансанд орсон эсэхийг тус газрын санхүүгээс шалгаж болно.

2.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөхөн төлбөрийг төлөхдөө хуваарьт улиралдаа багтаан боломжит нөхцлөөр төлөлт хийж болно.

2.5 Нөхөн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй бөгөөд төлбөрөө бүрэн төлсөн тохиолдолд төлбөрийн баримтыг Агентлагт ирүүлж, гэрээний хавсралтад гэрээ хариуцсан мэргэжилтнээр тэмдэглэл хийлгэн баталгаажуулна.

2.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2.1 дэхь хэсэгт заасан хугацаанда төлбөрөө улиралдаа багтаан төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд тухайн улиралд төлбөл зохих төлбөрийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.

2.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээний хэрэгжилттэй холбогдсон аливаа асуудлаар Агентлагт бичгээр хүсэлт гаргаж болох бөгөөд Агентлаг нь 30 хоногийн дотор хариу ирүүлнэ.

Гурав. Ашигт малтмал, газрын тосны газрын эрх, хүлээх үүрэг

3.1. Агентлаг энэхүү гэрээний хэрэгжилттэй холбогдуулан Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардлагатай бүхий л мэдээллийг авна.

3.2 Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилтийг хангах асуудлаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчид дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.

3.3 Гэрээний хэрэгжилттэй холбоотой нөхөн төлбөр төлөхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах,

3.4 Энэхүү гэрээний 1.1-дэх хэсэгт заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд өөрийн санаачилгаараа өөрчлөхгүй байх.

3.5 Нөхөн төлбөр хийсэн хугацааг банкинд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.

3.6 Нөхөн төлбөр төлсөн баримт бичигтэй танилцан төлбөрийн хэмжээ үнэн зөв төлсөн эсэхийг Агентлагийн санхүүгийн хуулгатай тулган, гэрээний хавсралтад төлбөр төлсөн талаар тухай бүр тэмдэглэл үйлдэж баталгаажуулна.

3.7 Нөхөн төлбөрийн гэрээ байгуулахад:

а. Ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан нөхөн төлбөрийн төлөх хугацааг ТЭЗҮ, уулын ажлын тайлан болон төлөвлөгөөнд тулгуурлан АМГТГ-ын Уул уурхайн үйлдвэрлэл технологийн хэлтэс,

б. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардалд ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан нөхөн төлбөрийн тооцооллыг АМГТГ-ын Геологи хайгуулын хэлтэс,

с. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардалыг нөхөн төлөх гэрээ боловсруулах, нөхөн төлбөрийн хуваарь гаргах, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавихыг Хууль, эрх зүйн хэлтэс тус тус хариуцана.

Дөрөв. Хариуцлага, маргаан шийдвэрлэх

4.1 Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдол Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн төлбөр төлөх тухай мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.7-д заасан нөхөн төлбөр, алдангийг төлөх, хугацаандаа төлөөгүй тохиолдолд АМГТГ нь тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авч болно.

4.2 Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой аливаа маргаан гарсан тохиолдолд талууд маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд Талууд маргааныг шийдвэрлэх зорилгоор саналаа бичгээр нөгөө талдаа хүргүүлснээс хойш ажлын 30 хоногийн дотор маргааныг шийдвэрлэх боломжтой талаар санал нэгдээгүй бол Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.3 Гэрээтэй холбоотой аливаа маргааныг аж ахуйн нэгж нь энэхүү гэрээний заалтыг биелүүлээгүй тохиолдолд Ашигт малтмал, газрын тосны газар нь шүүхэд хандаж болох бөгөөд шүүх ажиллагаатай холбогдон гарах зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцана

Тав. Гэрээ хүчин төгөлдөр болох, гэрээний хугацаа

5.1. Агентлаг болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарагдаж баталгаажуулснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.

5.2. Энэхүү гэрээний 2.1 дэхь заалтын биелэлтийг Агентлаг болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид хамтран дүгнэж акт үйлдэж гэрээг дуусгавар болгоно.

5.3. Гэрээг Монгол хэл дээр, гурван хувь үйлэх бөгөөд нэг хувийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, нэг хувийг Ашигт малтмал, газрын тосны газар /ХЭЗХ/, нэг хувийг ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч тус тус хадгална. Гэрээний хувиуд нэгэн адил хүчин төгөлдөр байна. Гэрээ ᠕ хуудас, хавсралт ᠕ хуудас, нийт ᠑᠐ хуудаастай.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

6.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд уг нөхцлөөс шалтгаалан үүргээ биелүүлээгүй талыг буруутай гэж үзэхгүй.

6.2 Энэхүү гэрээний 5.1-д заасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд талууд даруй харилцан мэдэгдэж шийдвэрдэх арга замыг тодорхойлно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ашигт малтмал, газрын тосны газрыг төлөөлж:

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА..... Ж. БАТМАГНАЙ

ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА..... М.БАТБАЯР


УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д. ХАНГАЙ

БОЛОВСРУУЛСАН: ХЭЗХ-ийн
МЭРГЭЖИЛТЭН..... Б.БОЛОРЦЭЦЭГ

“АРЕВА МАЙНС” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ: ~~Ж. Б. ХОРОО~~ ПЛЭЗАНТ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 1-р хороо, Жамьян Гүний гудамж,
ISS Tower 3-р давхар
Утас: 11-320698

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай-3,
E-mail: info@mram.gov.mn, Факс:31-03-70
Утас:263922



Хавсралт №1

2017 онд

Улирлууд	Төлбөл зохих төлбөр /төгрөг/	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3				
2017.10.31	149.217.877,5		149.217.877,5	2017.10.27

2018 онд

Улирлууд	Төлбөл зохих төлбөр /төгрөг/	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2	298.435.755			
3				
4				

2019 онд

Улирлууд	Төлбөл зохих төлбөр /төгрөг/	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2	298.435.755			
3				
4				

2020 онд

Улирлууд	Төлбөл зохих төлбөр /төгрөг/	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2	746.089.385,17			
3				
4				